
МЭДЭЭ · 2021 оны 6-р сарын 14

"БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ" АЯНЫ ХҮРЭЭНД ХҮҮХДҮҮДИЙН ДУНД ГАР ЗУРГИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ



Сүхбаатар дүүргийн прокурорын газраас "Байгалиа хамгаалъя" аяны хүрээнд дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, дүүрэг дэх Цагдаагийн газартай хамтран 14 хүртэлх насны хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулж, шилдэг

бүтээлүүдийг шалгаруулллаа.

Байгаль эхийнхээ ногоон ургамал, ус амьтныг хайрлан хамгаалах арга ухаанд хүүхэд, багачуудыг суралцуулж, байгальд ээлтэй болгож хүмүүжүүлэх зорилгоор зохион байгуулсан энэхүү уралдааны “Тэргүүн” байранд Д.Уянгагэрэл, “Дэд” байранд Х.Хангал, “Гуравдугаар” байранд Н.Сарнай нар шалгарч мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлээр шагнуулсан байна.

Шалгарсан бүтээлүүдийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд ашиглах юм.





Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2553